



PRAKSIS
THE JOURNAL OF ASIAN SOCIAL DEMOCRACY

Volume 1
Issue 3
November 2021



**INEQUALITY:
ADDRESSING ASIA'S
GREAT SCOURGE**





PRAKSIS is a biannual publication of the Network of Social Democracy in Asia (Socdem Asia). It seeks to combine theory and practice by providing cogent analyses to inform the strategy of the progressive movement and help shape the policy direction that should guide the region's governments.

Marie Chris Cabrerros
Network Coordinator

Francis Isaac
Editor-in-Chief

Carlo Angelo Vargas
Communications Officer and Editorial Assistant

Nando Jamolin
Art and Design Assistant

Marlon Cornelio
Program Coordinator

Bea Reyno
Network Secretary

Editorial Board and Steering Committee

Nurima Ribeiro Alkatiri
Marie Chris Cabrerros
Rafaela David
Francis Isaac
Anurag Shanker
Piyabutr Saengkanokkul
Sondang Tampubolon
Teo Nie Ching

Network of Social Democracy in Asia
Unit 3-E, 112 Maginhawa Street, Barangay Teachers' Village East,
Quezon City 1101

Website: www.socdemasia.com Facebook: facebook.com/SocDemAsia
E-mail: secretariat@socdemasia.com

TRANSFORMING MONGOLIA

Reducing Inequality and Enhancing Economic, Social, and Cultural Rights

By: Amarbat Uurtsaikh

Party Initiatives on Human Rights

The Mongolian People's Party (MPP) is the ruling party in Mongolia, which was established 100 years ago on 1 March 1921. The incumbent President of Mongolia was nominated by MPP. The Party has successfully participated in elections for the Citizens Representative Khurals of the country's 21 provinces, as well as in local elections in the capital city of Mongolia, Ulaanbaatar. MPP currently has a majority in 13 provinces and in Ulaanbaatar. We have successfully participated in several elections and have gained the trust and support of the public. In this regard, MPP is leading the initiative to become an organization that supports human rights, aiming to develop Mongolia into a country that respects human rights and freedom, and enabling its citizens to exercise their rights.

Emphasis on Economic, Social, Cultural Rights and Equality

In 1946, the United Nations adopted the Universal Declaration of Human Rights, followed by the International Covenant on Civil and Political Rights and the International Covenant on Economic, Social and Cultural Rights in 1966. The rights contained in these documents are also reflected in the current legislation of Mongolia. Historically, in the period between the People's Revolution of 1921 and the Democratic Revolution of 1990, our country has focused on the economic, social, and cultural rights of its citizens. Since the 1990s, however, more focus has been given on the exercise of civil and political rights, such as the right to vote, to be elected, to speak, to publish, and to be free from torture.

In order to implement MPP's initiative to become an organization that supports human rights, a comprehensive study of the human rights situation in Mongolia was conducted by leading researchers, for the first time. Specific human rights issues have been studied, but the situation as a whole has not been assessed, with each of the more than 12,000 provisions of the more than 320 existing laws never being assessed for human rights violations. Therefore, this study is of fundamental importance for us to map out a comprehensive roadmap for human rights protection.

The main findings of this study show that there is significant inequality in the realization of economic, social, and cultural rights. Hence, this article emphasizes economic, social, and cultural rights as well as inequality.



Image: www.ifj.org

“Economic, social, and cultural rights must be taken into account in order to achieve the fundamental goals of social democracy.

Economic, social, and cultural rights must be taken into account in order to achieve the fundamental goals of social democracy. Therefore, the exercise of the above-mentioned rights is presented as the key goal for the successful implementation of the human rights initiative of MPP.

Issues of Inequality Within the Sphere of Economic, Social, and Cultural Rights

Economic, social, and cultural rights include the universal right to an adequate standard of living,

physical and mental health, social security, health protection, education, and labor. It is often not possible for countries to fully implement all their economic, social, and cultural rights in a short period of time,¹ but the government is responsible for using all its domestic resources to the best of its ability to provide appropriate, equitable and quality basic services to society, families, and citizens.²

However, the government is obliged to immediately provide legal guarantees for the exercise of

certain economic, social, and cultural rights. These include: women and men must be equal in economic, social, and cultural relations; ensure equal pay for all employees and equal work without discrimination; guarantee the right of workers to form trade unions or to organize strikes; protect children and adolescents from economic and social oppression; provide compulsory and free primary education to everyone; and respect the freedoms necessary for scientific research and artistic activity, among others.³ The research highlights the various forms of inequality that hinder Mongolia's citizens from fully enjoying their economic, social, and cultural rights.

1. Inequality in labor relations and the system of protection of victims

- Although the Constitution and other relevant laws prohibit discrimination, illegal restrictions, and unfair privileges in labor relations, comprehensive anti-discrimination regulations, including on the basis of sexual orientation, gender identity, disability, marital status, and marital status, were weak in Mongolia. It was progressively amended in 2021 by the Labor Law, which was revised by the Parliament of Mongolia. However, the implementation of the law has not been effectively addressed, including issues such as the prevention of re-victimization of employees who have complained of discrimination, and the improvement of awareness, knowledge, and attitudes towards discrimination among dispute resolution bodies and their officials.

¹ See CESCR General Comment No. 3: The nature of States Parties' Obligations (Art.2, Para. 1 of the Covenant) para 9.
² See International Covenant on Civil and Political Rights, Article 2. Retrieved from: <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/ccpr.aspx>.
³ See International Justice Resource Center, 'Economic, Social and Cultural Rights.' Retrieved from: <https://ijrcenter.org/thematic-research-guides/economic-social-and-cultural-rights-2/>.

2. Inequality in the exercise of the right to education -

Education is a human right guaranteed by the Mongolian Constitution and international human rights laws, and is an indispensable tool for the guaranteed and effective exercise of other rights and freedoms. In particular, education is a tool for economically and socially marginalized groups (such as low-income earners, children, and people with disabilities) to overcome poverty. Education plays an important role in empowering women, protecting children from

hard labor and sexual exploitation, promoting human rights and democracy, and protecting the environment.⁴The law is responsible for ensuring the availability, accessibility, acceptability, and adaptability of education, as set out in international treaties. Despite ongoing changes in education policy and legislation, there is a need for sustainable policies, sound governance strategies, adequate budgets, adequate financial resources, and efficient allocation of resources, which are essential in ensuring effective implementation.

“The government is obliged to immediately provide legal guarantees for the exercise of certain economic, social, and cultural rights.

Image: www.reuters.com



The most pressing part in ensuring these rights is in creating opportunities for minimizing inequality of education services between ethnic minorities in the west of Mongolia (namely the Tsaatan people living in the northern taiga), children from families working in mining areas, children with disabilities, and those from state-owned districts in the suburbs of the capital on one hand, and that of children attending private schools for US\$40,000 a year on the other.

3. Inequality in the exercise of the right to free trade and business -

Although the Constitution of Mongolia does not specifically provide for the right to trade freely and to make a profit from doing business, this right is the most important right in a free market society. We assessed the fairness of the legal framework for property rights, free trade, and the business environment. Inequitable requirements and conditions are not uncommon due to corruption, which requires government agencies to set uniform standards and enforce them fairly. The Prime Minister of Mongolia is working to establish a National Anti-Corruption Commission to address this issue, but only through long-term commitment can this issue be addressed. Recently, farmers in Mongolia protested against the ban imposed by government officials on the sale of their crops in the capital city, and the government intervened with its decision to side with the farmers. Without legalizing the right to free trade, this type of issue will likely occur again.

The priority is to minimize inequality by developing and implementing solutions to each of the three above-mentioned issues.

⁴See CESCR, General Comment No. 13: The Right to Education (Art. 13) (1).



Image: www.culturalsurvival.org

“Equality can be achieved by actively cooperating with various stakeholders, rigorously enforcing standards and requirements, and confronting the root cause rather than challenging its symptoms.

Conclusion

Inequality is caused by various social, economic, and political conditions and policies, and if left unchecked, it can be exacerbated. Inequality widens the gap between the rich and the poor. On the other hand, social democracy seeks to keep the prosperous middle class as the majority of the population. In order to create a prosperous middle class, it is essential to reduce inequality in access to education and healthcare, thereby reducing disparities in the exercise of the right to work and to live in a healthy and safe environment.

Therefore, the MPP human rights initiative is based on the necessity of the current times. Under this initiative, we are introducing the following four main objectives:

1. A comprehensive assessment of the human rights situation in Mongolia. To this end, we have started conducting the above-mentioned research and four other studies, and have commenced the process of drawing conclusions from the research findings.
2. Introduce provisions to ensure and protect human rights in the more than 320 laws currently in force in Mongolia, and repeal provisions that violate human rights.
3. Establish an effective system for the protection of human rights and the restoration of violated rights by public officials responsible for the protection of human rights.
4. Cooperate with domestic and international organizations in the field of human rights protection and raise citizens' knowledge and awareness about human rights and its issues.

Inequality does not arise spontaneously, but is caused by unfair systems, poor government decisions and legislation, unequal criteria for public administration by government authorities, and a lack of public awareness of human rights. Therefore, we believe that equality can be achieved by actively cooperating with various stakeholders, rigorously enforcing standards and requirements, and confronting the root cause rather than challenging its symptoms. ■

“ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛЖ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ НЬ”

Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хуульч Ү.Амарбат

Нэг. Хүний эрхийг дээдэлдэг нам санаачилгын тухай

Монгол Ардын Нам нь 1921 онд байгуулагдсан, 100 жилийн түүхтэй, Монгол Улсын Их Хуралд олонхийг бүрдүүлдэг. Монгол Улсын Ерөнхийлөгч тус намаас нэр дэвшин сонгогдсон байдаг. Мөн Монгол Улсын 21 аймаг, нийслэл хотын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд амжилттай оролцож одоогоор 13 аймаг, нийслэл хотод олонхийг бүрдүүлдэг болно. Бид удаа дараагийн сонгуулиудад амжилттай оролцож, олон нийтийн итгэл дэмжлэгийг хүлээсэн билээ. Тийм ч учраас Монгол Ардын намаас “Хүний эрхийг дээдэлдэг нам” болох санаачилгыг дэвшүүлж ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ дээдэлдэг, иргэний зайлшгүй эдлэх ёстой эрхүүдийг эдлэх нөхцөл бололцоог хангасан улс болох зорилгыг тавьсан.

Хоёр. Эдийн засаг нийгэм соёлын эрх ба тэгш байдлыг чухалчлах нь

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1946 онд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталж, улмаар 1966 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактыг баталсан. Эдгээр бичиг баримтуудад туссан эрхийг Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжуудад мөн тусгасан. Харин түүхэн талаасаа манай улс 1921 оны Ардын хувьсгалаас 1990 оны Ардчилсан хувьсгал хүртэл хугацаанд иргэдийнхээ эдийн засаг нийгэм, соёлын эрхүүдийг эдлүүлэх чиглэлээр илүүтэй анхаарч байсан байна. Тэгвэл 1990 оноос хойш иргэний болон улс төрийн эрхүүд болох сонгох, сонгогдох, үг хэлэх хэвлэн нийтлэх, халдашгүй чөлөөтэй байх, эрүүдэн шүүлтээс ангид байх зэрэг эрхүүдийн хэрэгжилтийг чухалчлах болжээ.

Монгол Ардын Намын зүгээс “Хүний эрхийг дээдэлдэг нам” санаачилгыг хэрэгжүүлэхийн тулд хамгийн эхлээд Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг анх удаа иж бүрэн үнэлж дүгнэсэн бүрэн судалгааг тэргүүлэх судлаачдаар гүйцэтгүүлсэн болно. Монгол Улсын хувьд хүний эрхийн тодорхой асуудлуудыг судалж байсан боловч нөхцөл байдлаа бүхэлд нь үнэлж, хүчин төгөлдөр 320 орчим хуулийн 12000 гаруй заалт тус бүр нь хүний эрхийг зөрчсөн эсэхийг дүгнэж байсан удаагүй юм. Тиймээс энэхүү судалгаа нь биднийг хүний эрхийг хамгаалах иж бүрэн замын зураг гаргахад суурь ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны үндсэн дүгнэлтүүдээс үзэхэд Монгол Улсад эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийн хүрээнд тэгш бус байдал нэлээдгүй бий болсон байна. Тийм ч учраас энэхүү нийтлэлдээ эдийн засаг нийгэм соёлын эрх ба тэгш бус байдлыг чухалчлан үзэж байгаа болно. Мөн нийгмийн ардчиллын үндсэн зорилтуудад хүрэхэд эдийн засаг нийгэм соёлын эрхүүдийг чухалчлан авч үзэх зайлшгүй шаардлагатай байдаг. Тийм ч учраас нийгмийн ардчилсан үзэл баримтлалтай Монгол Ардын Намаас хэрэгжүүлж буй “Хүний эрхийг дээдэлдэг нам” санаачилгын хүрээнд эдийн засаг нийгэм соёлын эрхүүдийн хэрэгжилтийг сайжруулах нь түлхүүр зорилт болгон дэвшүүлсэн юм.

Гурав. Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хүрээн дэхь тэгш бус байдлын асуудлууд

Эдийн засаг, нийгэм, соёлын эрх нь хүн бүрийн амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, бие бялдарын болон сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн хангамж хүртэх, эрүүл мэндээ хамгаалуулах болон сурч боловсрох хөдөлмөрлөх эрхүүдийг хамардаг. Улсууд эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх нь ихэнхдээ боломжгүй¹ байдаг ч төрөөс нийгэм, гэр бүл, иргэн бүрт шаардлагатай суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэхэд зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд өөрийн дотоодын бүхий л нөөцийг боломжийнхоо хэрээр ашиглах² үүрэгтэй.

Харин эдийн засаг, нийгэм, соёлын зарим эрх хэрэгжих хууль зүйн баталгааг нэн даруй бүрдүүлэх үүрэгтэй. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд эмэгтэй, эрэгтэй хүмүүс адил тэгш байх; бүхий л ажилтанд шударга цалин олгох, аливаа ялгаваргүйгээр ижил хөдөлмөрт адил хөлс олгох баталгааг хангах; үйлдвэрчний эвлэл байгуулах зэргээр эвлэлдэн нэгдэх, ажил хаялт зохион байгуулах; хүүхэд, өсвөр насныхныг эдийн засаг, нийгмийн дарлал мөлжлөгөөс хамгаалах; хүн бүрт бага боловсролыг заавал, үнэ төлбөргүй олгох; шинжлэх ухааны судалгааны болон уран бүтээлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардагдах эрх чөлөөг хүндэтгэх үүрэгтэй.³ Монгол Улсад эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хүрээнд тэгш бус байдлыг үүсгэж буй олон асуудлуудаас дараахыг судалгаануудад онцолж үзсэн байна.

- 1. Хөдөлмөрлөх харилцаан дахь тэгш бус байдал, түүнд өртсөн хохирогчдыг хамгаалах тогтолцоо** - Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хөдөлмөрийн харилцаанд хууль бус ялгаварлал, хязгаарлалт, давуу байдал тогтоохыг хориглосон хэдий ч бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн болон гэр бүлийн байдал гэх мэт үндэслэлийг багтаасан ялгаварлан гадуурхалтын эсрэг цогц зохицуулалт манай улсад дулимаг байсан. Үүнийг 2021 онд Монгол Улсын их хурлаас шинэчлэн найруулсан Хөдөлмөрийн тухай хуулиар дэвшилттэйгээр өөрчилсөн. Харин хуулийн хэрэгжилтийг үр нөлөөтэй хангах, ялгаварлан гадуурхалтад өртсөн хэмээн үзэж гомдол гаргасан хүн, ажилтныг гаргасан гомдолтой нь холбогдуулан дахин хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, маргааныг шийдвэрлэх байгууллага, алба хаагчдын ялгаварлан гадуурхалтын талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг дээшлүүлэх асуудал шийдэгдээгүй.
- 2. Сурч боловсрох эрхээ эдлэх явц дахь тэгш бус байдал** - Боловсрол нь Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх бөгөөд бусад эрх, эрх чөлөөг баталгаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгсэл юм. Ялангуяа, орлого багатай иргэд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх зэрэг эдийн засаг, нийгмийн хувьд маргиналчлагдсан бүлгийнхэн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, ажил хөдөлмөр эрхлэх зэргээр ядуурлаас ангижрах хэрэгсэл юм. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхижуулах, хүүхдийг хүнд хөдөлмөр, хөдөлмөрийн болон бэлгийн

¹ CESCR General Comment No. 3: The nature of States Parties' Obligations (Art.2, Para. 1, of Covenant) para 9.

² Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), 2 дугаар зүйл.

³ International Justice Resource Center, 'Economic, social and cultural Rights' <https://ijrcenter.org/thematic-research-guides/economic-social-and-cultural-rights-2/>

мөлжлөгөөс хамгаалах, хүний эрх, ардчиллыг дэмжих, байгаль орчныг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.⁴ Хууль олон улсын гэрээнүүдэд заасанчлан боловсролын хүрэлцээтэй (availability), хүртээмжтэй (accessibility), хүлээн зөвшөөрөгдсөн (acceptability), (adaptability) баталгааг хангах үүрэгтэй. Боловсролын салбарын бодлого, эрх зүйн зохицуулалтад тасралтгүй шинэчлэл өөрчлөлт хийгдсээр байгаа хэдий ч хэрэгжилтийн үр нөлөөг хангахад тогтвортой бодлого, оновчтой удирдлага стратеги, төсөв, санхүүгийн хангалттай нөөц, нөөцийн үр ашигтай хуваарилалт чухал. Монгол Улсын баруун хязгаарт суугаа үндэсний цөөнхийн төлөөлөл, хойд хязгаарын тайгад аж төрж буй Цаатан хүү, уул уурхайн олборлолтын бүсэд ажиллаж буй гэр бүлийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, жилийн 40000 долларын төлбөртэй хувийн сургуульд сурч буй хүүхдүүд, эсхүл нийслэл хотын хамгийн захын дүүргийн төрийн өмчийн сургуулийн сурагчдын авч буй боловсролын үйлчилгээ нь хамгийн бага ялгаатай байх боломжийг бүрдүүлэх нь энэхүү эрхийн хамгийн тулгамдсан хэсэг юм.

3. **Чөлөөтэй худалдаа бизнес хийх эрхээ хэрэгжүүлэх явц дахь тэгш бус байдал** – Монгол Улсын үндсэн хуулиар чөлөөтэй худалдаа эрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулж ашиг олох эрхийг тухайлан зааж өгөөгүй ч энэхүү эрх нь чөлөөт зах зээлийн нийгэм дэх хамгийн чухал эрх. Хөрөнгийн эрх хамгаалагдсан, чөлөөтэй худалдаа эрхлэх, бизнесийн орчны эрх зүйн зохицуулалт тэгш шударга байгаа эсэхэд бид судалгааны хүрээнд үнэлэлт дүгнэлт өгсөн. Төрийн байгууллагууд нэг жигд стандарт шаардлагыг тавьж, шударгаар түүнийгээ мөрдүүлэх авилга хээл хахуулаас үүдэж тэгш бус шаардлага, нөхцөл үйлчлэх асуудал бага бус байна. Монгол Улсын Ерөнхий сайд дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Авилгын эсрэг үндэсний комиссыг байгуулан ажиллаж эхэлж байгаа ч урт хугацааны тууштай ажиллагааны үр дүнд л дээрх асуудал шийдэгдэх юм. Саяхан манай улсад намар хураасан ургацаа тариаланчид нийслэл хотод нээлттэй худалдаалах явцад төрийн албан хаагчдаас үзүүлсэн хориглолтыг эсэргүүцсэн тэмцэл өрнөж, эцэст нь Засгийн газрын зүгээс уг асуудлыг тариаланчдад нээлттэйгээр шийдвэрлэсэн нь бүхэлдээ худалдаа чөлөөтэй хийх эрхийг хуульчлахгүйгээр ийм асуудал давтагдсаар байх төлөвтэй байна.

Дээрх гурван асуудал болоод бусад тулгамдсан асуудал тус бүрийг шийдвэрлэх арга зам, хувилбаруудыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар тэгш бус, ялгаатай байдлыг хамгийн бага түвшин аваачих нь тэргүүлэх зорилт юм.

Дөрөв. Дүгнэлт

Тэгш бус байдал нь нийгэм, эдийн засаг, улс төрийн янз бүрийн нөхцөл байдал бодлогоос болж үүсэн бий болдог ба хэрэв нэгэнт үүссэн тэгш бус байдлыг засч залруулахгүй бол энэ нь улам даамжирч үе уламжлагдах хандлагатай болдог. Харин тэгш бус байдал нь баян ядуугийн ялгааг нэмэгдүүлдэг. Харин нийгмийн ардчилсан үзэл санаа нь чинээлэг дундаж давхаргыг хүн амын олонх байлгахад чиглэдэг. Чинээлэг дундаж давхаргыг бий болгоход гарцаагүй боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дэх тэгш бус байдлыг эрчимтэйгээр бууруулах, улмаар хөдөлмөрлөх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ хэрэгжүүлэхэд ялгаатай байдлыг бууруулах нь чухал юм. Тиймээс Монгол Ардын намын хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн “Хүний эрхийг дээдэлдэг нам” болох санаачилга нь цаг үе нөхцөл байдлын зайлшгүй

⁴ CESCR, General Comment No. 13: The Right to Education (Art. 13) (1)

шаардлагад тулгуурласан юм. Энэхүү санаачилгын хүрээнд бид дараах үндсэн дөрвөн зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүний эрхийн нөхцөл байдлаа иж бүрэн үнэлэх. Үүний тулд дээр дурдагдсан судалгаа болон бусад 4 судалгааг хийж дүгнэлтүүдээ гаргаж эхлээд байна.
2. Монгол Улсад үйлчилж буй 320 гаруй хуулиудад хүний эрхийг хангаж, хамгаалсан зохицуулалтууд оруулах, хүний эрхийг зөрчсөн заалтуудыг хүчингүй болгох
3. Хүний эрхийг хангаж хамгаалах үүрэг бүхий төрийн байгууллага албан тушаалтнууд хүний эрхийг хамгаалдаг, зөрчигдсэн эрхийг сэргээдэг үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэх.
4. Хүний эрхийг хамгаалах чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх

Тэгш бус байдал нь аяндаа бий болдоггүй бөгөөд түүнийг бий болгох шударга бус тогтолцоо, төрийн гаргасан буруу шийдвэр, хууль тогтоомжууд, төрийн эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахдаа тэгш бус шалгуур шаардлага тавьж заншсан, иргэд олон нийтийн хүний эрхийн мэдрэмж хандлага доогуур зэргээс бий болдог. Тийм ч учраас дээрх олон талуудтай идэвхтэй хамтран ажиллах, үүссэн нөхцөл байдалтай зууралдаж биш үүсгэгч хүчин зүйлүүдийг өөрчилж шаардлага стандартыг ягштал мөрдүүлэх замаар тэгш байдлыг бүтээнэ гэж бид үздэг.

 /SocDemAsia

 www.socdemasia.com

**INEQUALITY:
ADDRESSING ASIA'S
GREAT SCOURGE**

